Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 141 дугаартай албан бичгийн хавсралт

# “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

/2022 оны 03 дугаар улирлын байдлаар/

2022 оны 09 дүгээр сарын 22 Багануур дүүрэг

| Д/д | Өргөдөл, гомдлын агуулга | Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо | Шийдвэрлэх шатандаа байгаа | | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | | | | | Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр | | | Өргөдлийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэх хугацаандаа байгаа | Хугацаа хэтэрсэн | 1-10 хоногт | 11-20 хоногт | 21-30 хоногт | Хугацаа сунгасан | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо | Албан бичгээр | Утсаар | Биечлэн уулзах | Талархал | Санал | Хүсэлт | Гомдол | Мэдэгдэл |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 1 | Ажил хүссэн | 1 | | | 1 | | | | | | | + | | | + | | |
| 2 | Дэмжлэг туслалцаа хүссэн | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл | 2 | | | 2 | | | | | | | + | | | + | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Бусад | | | | | | | | | | | | | | | | |
| | Нийт | 3 | | | 3 | | | | | | | 3 | | | 3 | | |

**Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал**

| № | Ангилал | Тоо | Шалтгаан, тайлбар |
|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 |
| 1 | Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл | 1+1+1 | |
| 2 | Боломжгүй тухай хариу өгсөн | - | Ирсэн өргөдлийг иргэн, ажилтан нарын хүсэлтийн дагуу шийдвэрлэсэн. |
| 3 | Бусад | - | - |

ХЯНАСАН: Ч.ЭЛБЭГСАЙХАН
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ПАРК” ОНӨТҮГ-ЫН ДАРГА

МЭДЭЭ ГАРГАСАН: М.МӨНХДУЛАМ
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД
ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-Т ИРГЭД, АЛБАН ХААГЧДААС ГАРГАСАН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 09 дүгээр сарын 22 Багануур дүүрэг

Манай байгууллагад 2022 оны 03 дугаар улирлын байдлаар иргэдээс ажилд орох 1, ажлаас чөлөөлөгдөх утгатай 2 өргөдөл ирсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал хүсэлтийн төрлийн хувьд төстэй, тооны хувьд цөөн байна. Тухайлбал, өнгөрсөн оны 03 дугаар улирлын байдлаар манай байгууллагад 4 өргөдөл ирсэн байна. Үүнд: 1 иргэнээс ажилд орох хүсэлт, 1 ажилтан ажлаас чөлөөлөгдөх, 2 ажилтан Коронавирусын халдвар авсан хүмүүсийн ойрын хавьтал болсон байх магадлалтай тул гэрээсээ цахимаар ажиллах хүсэлт гаргасан байна. Өргөдөл тус бүрийг "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын даргын тушаалаар хүсэлтийн дагуу өдөр, өдөрт нь багтаан шийдвэрлэсэн.

Дээрх өргөдлүүдийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтөлж, өргөдлүүд болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн тус тус архивласан. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

Иргэдээс байгууллагад хандаж гаргасан гомдол байхгүй.

Бүтээлч санал санаачлагын шинжтэй хүсэлт илэрхийлж, мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага байнга биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэ уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачлагын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн нэг илрэл нь Багануур дүүрэгт төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа МЕСЕС ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан гэрээ байгуулан ажиллаж байгаа явдал юм. Энэ ажлын хүрээнд Паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам болон 110/35кВт-ын үндсэн дэд станцын зураг төслийг ЭХЯ-наас олгосон техникийн нөхцөлийн дагуу боловсруулж Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-тай зөвшилцөж, нэмэлт өөрчлөлтийг оруулан баталгаажуулсан. Станцыг барьж байгуулах тендерт Энх өглөө ХХК шалгарч бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд бэлэн болоод байна. байна.

Мөн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Паркийн хүрээнд үйлдвэр байгуулах шинээр хэрэгжүүлэх эко төслийн саналуудыг хүлээн авч, нааштай шийдвэрлэх боломжууд нэмэгдэж байна.

Өргөдлийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэгт 2018 оноос эхлэн улирал бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.

Иргэдээс манай байгууллагын ажилтан, албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол байхгүй.

ХЯНАСАН: Ч.ЭЛБЭГСАЙХАН
"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН: М.МӨНХДУЛАМ
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН